

БАТЛАВ.  
 НИЙСЛЭЛИЙН ХОРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
 ГАЗРЫН ДАРГА Б МӨНХБАТ

**СУРГУУЛИЙН БАРИЛГА ХУДАЛДАН АВАХ 640 СУУДАЛ /БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 22 ДУГААР  
 ХОРОО/ АЖЛЫН ДААЛГАВАР**

2020 оны 2-р сарын 03-ны өдөр

№ 2020/07

Улаанбаатар хот

1	Үндэслэл	Шаардлага
2	Барилга байгууламжийн байршил	- Улаанбаатар хот. Баянзүрх дүүрэг 22 дугаар хороо
3	Зориулалт, хүчин чадал	- 640 хүүхдийн сургуулийн барилга
4	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	- Дулааны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон байх, эсвэл өөрийн эх үүсвэртэй байх. - Цахилгааны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон байх - Цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон байх, эсвэл өөрийн эх үүсвэртэй байх.
5	Галын аюулгүй байдлын нөхцөл	- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНБД 21.02.02/; - Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал /БНБД 21-01-02/
6	Өрөө танхим	Хүүхдийн сургууль нь норм, стандарт заагдсан өрөө тасалгаатай байна. <u>Барилга, байгууламжид зайлшгүй байвал зохих өрөө тасалгаа:</u> Ангийн өрөөнүүд, тусгай лабораторийн анги танхимууд хүлээн авах өрөө, ариун цэврийн өрөө, хөгжмийн анги, кабинетууд, гонх, коридор, шатны хонгил, захиргааны өрөө, эмчийн өрөө, тусгаарлах өрөө, багш ажилчдын өрөө, спорт заал, гал тогоо, агуулах гэх мэт
7		<u>Баримт бичгийн иж бүрдэл:</u> - Инженер геологийн дүгнэлт - Байр зүйн дэвсгэр зураг боловсруулах - Онцгой байдлын дүгнэлт - Магадлалын ерөнхий дүгнэлт /Хавсралт дүгнэлтийн хамт/
8	Төслийн иж бүрдэл	<u>Ажлын зургийн иж бүрдэл:</u> 1. Эскиз /батлагдсан/ 2. Ажлын зураг /батлагдсан/ - ЕТ- Ерөнхий төлөвлөгөө - БА- Барилга архитектур - ТХ-Технологийн зураглал - ББ- Барилга бүтээц /Бүтээцийн тооцооны хамт/ - ХС- Халаалт, салхивч - ЦБУ- Усан хангамж, ариутгах татуурга




		<ul style="list-style-type: none"> <li>- ЦА- Цахилгаан хангамж</li> <li>- ХД- Холбоо дохиолол</li> <li>- ГД- Гадна дулаан</li> <li>- УАТГ- Гадна усан хангамж ариутгах татуурга</li> <li>- ГЦ- Гадна цахилгаан</li> <li>- ГХ- Гадна холбоо</li> <li>- Барилгын төсөв /Тооцооны ESTIMATOR-PRO программ/ /батлагдсан/</li> </ul>
9	Онцгой нөхцөл	<p><u>Барилга байгууламж:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрчим хүчний хэмнэлттэй, ашиглалтын зардал бага байх</li> <li>- Ангийн сурагчдийн сурах, амрах, тоглох орчинг бүрдүүлсэн байх</li> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц, гарц, фандусыг норм дүрмийн дагуу төлөвлөсөн байх.</li> <li>- Агааржуулалт, салхивчийн нэгдсэн системийг норм нормативын дагуу төлөвлөх</li> <li>- Сургалтын танхимд нарны гэрэл шууд тусахаар төлөвлөх</li> <li>- Барилгын аврах гарцыг нормын дагуу төлөвлөх ба саадгүй түргэн аврагдах гарцыг төлөвлөх</li> </ul> <p><u>Гадна талбай:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ногоон байгууламж ба амрах талбай төлөвлөн, зам талбайд гэрэлтүүлэг хийж гадна талбайн тохижилтыг норм дүрмийн дагуу төлөвлөх</li> </ul> <p><u>Инженерийн шугам сүлжээ:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Халаах хэрэгсэл болон хаалт арматурыг бага насны хүүхдүүдийн аюулгүй байдал хангахаар хамгаалалттай хаалттай байх</li> <li>- Насны ангилалд тохирсон ариун цэврийн тоноглол төлөвлөх</li> <li>- Ослын гэрэлтүүлгийг орц гарц, коридорт төлөвлөх</li> <li>- Аудио систем төлөвлөх, гадна дотор хяналтын камер төлөвлөх</li> <li>- Мэдээлэл харилцаа, холбоо дохиоллын инженерийн шугам сүлжээний хэрэгцээ шаардлагыг хангахуйц төлөвлөх.</li> </ul>
10	Архитектур орон зайн төлөвлөлтөнд тавигдах шаардлага	<p><u>Барилга:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Анги хоорондох хонгил буюу коридорт хичээлийн хэрэглэл хийх шүүгээ тавихад сурагчдад зорчих зай талбай хангалттай байх</li> <li>- Нэг ангид байх хүүхдийн тоог стандартын дагуу тооцох</li> <li>- Багш нарын өрөө /том/, хичээлийн анги танхим, үйлчлэгчийн өрөө, ажилчдын ариун цэврийн өрөө, бусад шаардлагатай өрөө тасалгаа.</li> <li>- Лаборатори анги танхим, бусад шаардлагат өрөө тасалгаа.</li> <li>- Урлаг заал, спорт заал, гал тогоо болон түүний дагалдах өрөө тасалгааг норм дүрмийн дагуу төлөвлөх.</li> </ul>




11	Ерөнхий телевлегөө, Зураг төсөл боловсруулаха д ашиглах материал	<u>Хууль тогтоомжууд:</u> - Барилгын тухай Монгол улсын хууль - Боловсролын тухай хууль <u>Норм. нормативууд:</u> - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/; - Олон нийт иргэний барилгын норм дүрэм /БНБД 31.03.03/; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх /MNS 6056:2003, 6055:2009/; - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм; - Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12 - Бусад холбогдох норм, дүрэм;
12	Төлбөр тооцоо	- Нийлүүлэгч тал цахилгаан, дулаан, холбоо мэдээлэл, газар, татварын гэх мэт өр төлбөргүй байна.
13	Санхүүжилт	- Барилга байгууламжийг захиалагч байгууллагад акт үйлдэж хүлээлгэн өгсөнөөр гэрээнд тусгасан санхүүжилтийг 100 хувь нийлүүлэгч талд шилжүүлнэ.


ХЯНАСАН:  
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ЗТХ-ИЙН ДАРГА

  
..... /Б.ЛХАГВАЖАВ/

БОЛОВСРУУЛСАН:  
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ЗТХ-ИЙН ХЯНАЛТЫН ИНЖЕНЖР

  
..... /Б.УЯНГА/

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН  
ЕБС-ИЙН БАРИЛГА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
МЭРГЭЖИЛТЭН

  
..... /Э.БАЯРМАГНАЙ/